



МОНГОЛ
АМГАЙ
ТӨРИЙН
АУДИТ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН | 2022

АГУУЛГА

ХУРААНГУЙ ТАЙЛАН	3-5
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	6-9
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	10-12
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	13-16
НИЙЦЛИЙН АУДИТ	16
БУСАД АУДИТ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ.....	17-21
ДОТООД АЖИЛ	22-28
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	29
ДҮГНЭЛТ, САНАЛ	30
ХАВСРАЛТ 1 /Статистик мэдээ/	
ХАВСРАЛТ 2 /Хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөжийн бүртгэл/	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АГН	Аудитын гуравдугаар нэгж
АНГ	Аудитын нэгдүгээр нэгж
АНТАГ	Аймаг, нийслэлийн Төрийн аудитын газар
АХН	Аудитын хоёрдугаар нэгж
АНСДИТХСТ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай
ББНШК	Баримт бичиг нягтлан шалгах комисс
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГЗБЕТ	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө
ДАХШҮ	Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээ
ЖДҮДС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗХЭЗГ	Захиргаа, хууль эрх зүйн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ММНБ	Монголын мэргэшсэн нягтлан бодогч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНӨХЭ	Орон нутгийн өмчит хуулийн этгээд
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ТАЦНС	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТГТ	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмчит
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТЖА	Төрийн жинхэнэ албан хаагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАК	Хувийн аудитын компани
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхлын, хөрөнгө орлогын мэдүүлэг
ХБТГ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар
ХНУМС	Хүний нөөцийн удирдлага мэдээллийн систем
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СХС	Сум хөгжүүлэх сан
ЧБА	Чанарын баталгаажуулалтын алба
ШТА	Шууд тайлагналын аудит

ХУРААНГУЙ ТАЙЛАН:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/105 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах журам”-ын дагуу Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны үйл ажиллагааг тайлагнаж байна.

Статистик мэдээлэл:

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь 2022 онд санхүүгийн тайлангийн аудит 231, ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудит 1, нэгдсэн удирдамжтай гүйцэтгэлийн аудит 3, өмнөх оноос шилжиж ирсэн 1, өөрийн санаачилгат гүйцэтгэлийн аудит 2 нийт 238 аудит хийж гүйцэтгэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган батлуулсан.

Тайлант онд нотлох аудит 231, ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудит 1, нэгдсэн удирдамжтай шууд тайлагнах аудит 3, орон нутгийн төсвийн төсөлд дүгнэлт өгөх 1, өмнөх оноос шилжиж ирсэн 1, өөрийн санаачилгат 2, нэмэлтээр хийх, төлөвлөгөөт бус аудит 3 нийт 242 аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу бүрэн хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитыг хослуулан хийсэн.

Тайлант онд нийт 69,869.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 38,220.0 сая төгрөгийн 435 алдааг залруулж, 126.3 сая төгрөгийн 51 төлбөрийн акт тогтоож, 17,539.5 сая төгрөгийн 250 албан шаардлага, 13,983.2 сая төгрөгийн 366 зөвлөмж, 7 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ. /Хүснэгт №1/

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 онд тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн бүртгэл /сая төгрөгөөр/

/Хүснэгт №1/

№	Үзүүлэлт	Тайлант хугацаанд нэмэгдсэн		Хэрэгжилт		Эцсийн үлдэгдэл		Хэрэгжилтийн хугацаа болоогүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8
1	Төлбөрийн акт	51	126.3	40	40.3	11	86	-	-
2	Албан шаардлага	250	17,539.5	223	8,386.8	27	9,152.7	8	7,123.1
3	Зөвлөмж	366	13,983.2	313	13,918.5	53	64.7	20	0
4	Хариуцлага тооцох албан шаардлага	7	-	7	-	-	-	-	-
5	Нийт	674	31,649	583	22,345.6	91	9,303.4	28	7,123.1

Тайлант хэрэгжвэл зохих 51 төлбөрийн актаас 40 барагдаж 78 хувьтай, 242 албан шаардлагаас 223 хэрэгжиж 92.1 хувьтай, 346 зөвлөмжөөс 313 хэрэгжиж 90.4 хувийн биелэлттэй байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 9-18 хувиар өссөн байна.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны үлдэгдлээс хэрэгжсэн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж /сая төгрөгөөр/

/Хүснэгт №2/

Үзүүлэлт	Өмнөх оны үлдэгдэл		Биелэлт Өмнөх оноос		Эцсийн үлдэгдэл	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөрийн акт	18	25.1	6	12.8	12	12.3
Албан шаардлага	36	7,853.4	23	5,058.9	13	2,794.5
Зөвлөмж	154	7,956.5	129	5,881.5	25	2,075.0
Нийт	208	15,835.0	158	10,953.2	50	4,881.8

Өмнөх оны үлдэгдлээс 12.8 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 5,058.9 сая төгрөгийн 23 албан шаардлага, 5,881.5 сая төгрөгийн 129 зөвлөмж хэрэгжсэн.

Тайлант оны үлдэгдлийг өмнөх оны үлдэгдэлтэй харьцуулсан судалгаа
/сая төгрөгөөр/

/Хүснэгт №3/

Үзүүлэлт	Өмнөх оны үлдэгдэл		Тайлант оны үлдэгдэл /хугацаа хэтэрсэн/		Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөрийн акт	18	25.1	23	98.3	5	73
Албан шаардлага	36	7,853.4	32	4,824.2	(4)	(3,029)
Зөвлөмж	154	7,956.5	58	2,139.7	(96)	(5,817)
Нийт	208	15,835	113	7,062.2	(95)	(8,773)

Тайлант хугацаанд “Аудитын мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг сайжруулах ажлын хүрээнд 7 ажлыг хэрэгжүүлэхээр ажлын төлөвлөгөө боловсруулан гаргаж дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны А/28 дугаар тушаалаар баталгаажуулан ажилласнаар байгууллагын 2021 оны статистик мэдээний эцсийн үлдэгдлийг өмнөх онтой харьцуулахад нийт дүнгээр 46 хувиар буурсан байна.

Дэвшүүлсэн зорилт:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг МҮЕА-ын 2022 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “Чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах” Төрийн аудитын байгууллагын 2022 оны зорилт, А/12 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө” болон “Төрийн аудитын байгууллагын 2019-2024 онд хэрэгжүүлэх стратеги”, “Харилцагч талуудын оролцооны стратеги”, ТАБ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги зэрэгт үндэслэн боловсруулж, МҮЕА-ын орлогчоор батлуулан ажиллалаа.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд аудит болон дотоод үйл ажиллагаатай холбоотой 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасныг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, гүйцэтгэлийн тайланг ҮАГ-ын холбогдох газруудад хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/35 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2022 оны зорилтыг хангах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагад хамаарах 4 ажлыг бүрэн хэрэгжүүлэн тайланг тухай бүр ЧБА-д хүргүүлэн ажилласан.

ТАБ-ын 2022 оны зорилтыг хангах чиглэлээр байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны А/07 дугаар тушаалаар баталсан. Төлөвлөгөөнд аудитын чанарын хяналтыг сайжруулах чиглэлээр 5 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Тухайн ажлын тайланг гарган баталгаажуулж гүйцэтгэлийн төлөвлөгөөний нотлох баримтаар ҮАГ-т хүргүүлсэн.

Аудитын үр өгөөж:

Тайлант хугацаанд нийт 18,905.2 сая төгрөгийн үр өгөөжийг шалгадагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд нэг төгрөг ногдох үр өгөөж 40.9 төгрөг байна. Энэ нь өмнөх оны үр өгөөжөөс 3 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаас өмнөх оны актын барагдуулалт 12.8 сая төгрөг, тайлант оны төлбөрийн акт, авлага, хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 352.0 сая төгрөг нийт 364.8 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн.

Тухайн онд гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитаар тогтоосон хөрөнгийг бүртгэлд тусгах тухай албан шаардлагын биелэлтийг үр өгөөжөөр хүлээн зөвшөөрүүлснээс 4,274.0 сая төгрөг, “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт үр нөлөө” сэдэвт аудитаар тогтоосон хөрөнгийг бүртгэлд тусгах тухай албан шаардлагын биелэлтийг үр өгөөжөөр хүлээн зөвшөөрүүлснээс 775.6 сая төгрөг, “Орон нутгийн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит” аудитаар өгсөн зураг төсөвгүй ТАХ-г хасах зөвлөмжийн биелэлтийг үр өгөөжөөр хүлээн зөвшөөрүүлснээс 13,490.8 сая төгрөгийн нийт 18,540.4 сая төгрөгийн үр өгөөжийг холбогдох байгууллага албан тушаалтнаар хүлээн зөвшөөрүүлж ажиллалаа.

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Дэвшүүлсэн зорилтын биелэлт:

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/35 тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2022 оны зорилтыг хангах ажлын төлөвлөгөөнд өөрийн байгууллагад хамаарах дараах 4 ажлыг бүрэн хэрэгжүүлэн тайланг ЧБА-д хүргүүлсэн.

1. **"Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний үр нөлөө" сэдэвт аудитын тайланг Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэх:** "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний үр нөлөө" сэдэвт аудитын тайланг 2022.09.30-ны өдөр дуусгавар болгон аудитын тайланг аудитын баг, аудитын менежер, тэргүүлэх аудитораар хэлэлцэн дүгнэлт, зөвлөмжийг гарган тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн. Төв аймаг дахь Төрийн аудитын газраас аудитын тайлантай холбоотой хэлэлцүүлгийг 2022.11.04-ний өдөр явуулж аудитын баг оролцон нэгтгэл тайланд оруулах асуудлыг тодорхой болгосон. Тайлангийн нэгтгэлтэй холбоотой цахим хэлэлцүүлгийг УАГ-аас 2022.12.22-ны өдөр хийж өөрийн тайлантай холбоотой гарсан асуултад хариулт өгч хэлэлцүүлгээс гарсан шийдвэрийн дагуу Төв аймгийн ТАГ-т нэгдсэн тайлангийн дүгнэлт, зөвлөмжид оруулах саналаа өгсөн.
2. **"Чанарын хяналт болон нэгдсэн удирдлага хоёрын харилцан уялдаа, цаашдын чиг хандлага" сэдвээр сургалт зохион байгуулах:** Тус сургалтыг нэгдсэн журмаар цахимаар зохион байгуулах хүсэлтийг АНТАГ-уудаас гаргасан саналын дагуу АНГ-ын менежер 2022.06.22-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Сургалтад дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, аудитор нар бүрэн хамрагдсан. Сургалтын дараа ярилцлага хийж, албан хаагчдын сонирхсон асуултад АНГ-ын менежер Ж.Батсайхан, ХБТГ-ын менежер Цэнгүүн нар хариулт өгч сургалт үр дүнтэй, өгөөжтэй болсон.
3. **"Аудитын чанарын хяналтын тогтолцоо" сэдвээр дотоод сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг үнэлэх:** Тус сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн 13 АНТАГ хамтран, ХБТГ-т хүсэлт тавьсны дагуу АНГ-ын менежер Ж.Батсайхан тус сургалтыг цахимаар зохион байгуулж, аудитын чанарын хяналтын үе шат, тогтолцоо, анхаарах зүйлсийн талаар мэдээлэл өглөө. Мөн сургалтад оролцсон 13 аймгийн албан хаагчид болон өөрийн байгууллагын аудиторуудын дунд /онлайн сургалтын дараа/ асуулт, хариулт, "Аудитын чанарын хяналтын тогтолцоо" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Аудиторуудын дунд явагдсан хэлэлцүүлгээр чанарын хяналтыг хэрэгжүүлэгч ахлах аудитор, багийн ахлагч нарт тухайн аудитын асуудлыг бага хуваарилснаар өдөр тутмын хяналт сайжирна гэсэн дүгнэлтэд хүрч цаашид ажлын хуваарилахад анхааран ажиллахаар шийдвэрлэлээ. Сургалт зохион байгуулснаар аудитын хяналтын чанарын тогтолцооны талаар мэдлэг сайжирсан.
4. **УАГ-аас холбогдох чиглэлүүдээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, зөвлөмж авах:** Чанарын баталгаажуулалтын албанаас 2022.09.22-ны өдөр ЧБА-ны дарга С.Оюунгэрэл цахим сургалт зохион байгуулсан. Тус сургалтаар чанарын хяналтыг хэрэгжүүлэх, аймгууд түншийн үнэлгээг хэрхэн хийх талаар сургалт зөвлөмж өгч мэдлэг, мэдээлэлтэй болсон. Тус сургалтын үр дүнд Дорнод аймгийн ТАГ-тай харилцан түншийн үнэлгээг 2022.10.16-2022.10.19-ний өдрүүдэд хийж тайланг боловсруулан гаргасан. Түншийн үнэлгээ хийснээр өөрийн байгууллагын чанарын хяналтад цаашид анхаарах асуудал, сайн талыг мэдэж ажилдаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТАБ-ын 2022 оны зорилтыг хангах чиглэлээр байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны А/07 дугаар тушаалаар баталсан. Төлөвлөгөөнд дараах 5 ажлыг төлөвлөн бүрэн хэрэгжүүлсэн.

[illegible]

A group of people are seated around a large, polished wooden conference table in a meeting room. They are all looking towards a large screen at the front of the room, which displays a presentation with a flowchart. The room has wood-paneled walls, a coat rack, and bookshelves. The people are dressed in business casual attire. The presentation on the screen shows a flowchart with several boxes and arrows, likely related to the 'Business Process Management' topic mentioned in the text.

Хүний нөөцийн зохион байгуулалт:

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн аудитын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын 2021 оны А/02 дугаар тушаалаар “Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл”-ын дагуу дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер, дэмжих үйлчилгээний нэгж болон төрөлжсөн аудитын 3 нэгжид 12 албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна.

Тус төрийн аудитын байгууллага нь ажилчдын чадавхыг бэхжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах, тасралтгүй сурган хөгжүүлэх, ажиллах нөхцөл, цалин урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхааран ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/19 дүгээр тушаалаар Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 12 орон тоо батлагдсан бөгөөд тайлант хугацаанд үндсэн орон тоонд 12 албан хаагч ажиллаж нийт 2298 хүн/өдөр, 7426 илүү цагаар ажилласан байна. Тайлант хугацаанд хүүхэд асрах чөлөөтэй ахлах аудитын О.Нарангаравын оронд аудитор Т.Мөнхтогтох, нөхөн томилгоо хийгдээгүй байсан ахлах аудитын сул орон тоонд аудитор Л.Равдандорж нар дэвшин томилогдсон. Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/126 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг дахь Төрийн аудитын газрын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах тухай” тушаал, ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу гэрээт үйлчлэгч О.Нарантуяаг 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээг аймгийн Нийтлэг үйлчилгээний газраас хариуцан хийж байна.



Аудитор Т.Мөнхтогтохын орон тоонд аудитор, нягтлан бодогчоор М.Дүүрэнжаргалыг түр томилуулах саналыг ҮАГ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Нийт албан хаагчдаас магистр цолтой 5, ММНБ-8, санхүү, эдийн засагч мэргэжилтэй 11, санхүү-эрх зүйч хосолсон мэргэжилтэй 2 аудитор ажиллаж байна. Нийт албан хаагчдын 75 хувь нь 40 хүртэл насных байна.

Гүйцэтгэсэн аудит:

Тайлант онд нотлох аудит 231, ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудит 1, Нэгдсэн удирдамжтай шууд тайлагнах аудит 3, өмнөх оноос шилжиж ирсэн 1, өөрийн санаачилгат 2, нэмэлтээр хийх, төлөвлөгөөт бус аудит 3 нийт 241 аудитыг хийж гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаа.

Санхүүгийн тайлангийн аудит: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 14, төсвийн шууд захирагчийн 115 /ТШЗ-112, ЗГТС-3/ төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 9 нийт 139 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, төсвийн шууд захирагчийн 63, сум хөгжүүлэх сангийн 14, орон нутгийн хөгжлийн сангийн 15 тайлан нийт 92 тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж гүйцэтгэлээ. /хүснэгт №4/

**Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн
шийдвэрлэлт, барагдуулалт /сая төгрөгөөр/**

/Хүснэгт №4/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Тайлант хугацаанд нэмэгдсэн		Хэрэгжилт бүгд		Эцсийн үлдэгдэл	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	1	2	3	4	9	10	21	22
Төлбөрийн акт	15	17.2	48	120	46	53.1	17	84.1
Албан шаардлага	23	5,091.2	220	1,775.5	227	6,595.1	16	271.6
Зөвлөмж	114	2,515.5	262	492.4	332	2,900.1	44	107.8
Нийт	152	7,623.9	530	2,387.9	605	9,548.3	77	463.5

Тайлант хугацаанд өмнөх оны үлдэгдэл болон тайлант хугацааны нийт барагдвал зохих 63 актаас 46 барагдаж 53.1 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Харин 243 албан шаардлага барагдахаас 227 барагдаж 6,595.1 сая төгрөгийн зөрчлийг арилгасан байна. Тайлант хугацаанд хэрэгжвэл зохих 376 зөвлөмжөөс 332 барагдсан байна. Тайлант онд хэрэгжвэл зохих төлбөрийн акт албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 88.3 хувьтай байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 364.8 төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэн ажиллаа. Хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөжийн 53.1 сая төгрөг нь төлбөрийн актаас, 311.7 сая төгрөг нь хөрөнгийн бүртгэл, авлага, зардалтай холбоотой залруулгаас гарсан байна.

Шууд тайлагнах аудит: ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудит 1, орон нутгийн төсвийн төсөлд санал өгөх аудит 1, нэгдсэн удирдамжтай шууд тайлагнах аудит 3, өмнөх оноос шилжиж ирсэн 1, өөрийн санаачилгат 2, нэмэлтээр хийх, төлөвлөгөөт бус аудит 3 нийт 11 аудитыг төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хугацаанд гүйцэтгэн баталгаажуулж, холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүллээ.

**Шууд тайлагнах аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн
шийдвэрлэлт барагдуулалт /сая төгрөгөөр/**

/Хүснэгт №5/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Тайлант хугацаанд нэмэгдсэн		Хэрэгжилт бүгд		Эцсийн үлдэгдэл		Хугацаа болоогүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөрийн акт	3	7.9	3	6.3	-	-	6	14.2	-	-
Албан шаардлага	13	2,762.2	30	15,764	19	6,850.6	24	11,675.7	8	7,123.1
Зөвлөмж	40	5,441	104	13,490	110	13,490.1	34	5,441	20	-
Нийт	56	8,211.1	137	29,261	129	20,340.7	64	17,130.9	28	7,123.1

Тайлант хугацаанд нийт 37,471.6 сая төгрөгийн 193 төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжихээс хугацаа болоогүй 7,123.1 сая төгрөгийн 28 зөрчлийн шийдвэрлэлт байна. Нийт 30,348.5 сая төгрөгийн 165 төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжихээс 20,340.7 сая төгрөгийн 129 төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжиж 78.2 хувийн хэрэгжилттэй байна.

Тайлант хугацаанд шууд тайлагнах аудитаар 18,540.4 сая төгрөгийг үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн.

ХОЁР: САНХҮҮГИЙН АУДИТ



Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 231 байгууллага, тусгай сангуудыг аудитад хамруулахаас 231 төсөв захирагч, сан, ТБОНӨААН-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Үүнээс 71.4 хувь буюу 165 тайланг Төрийн аудитын газар, 28.6 хувь буюу 66 тайланг хувийн аудитын 2 компаниар гүйцэтгүүллээ.




Санхүүгийн тайлангийн аудитыг ТАГ-ын 9 аудитор, 1 гэрээт аудитораар гүйцэтгэж, 512 хүн-өдөр, 2302 илүү цаг ажилласан байна.

МУЕА-ын 2020 оны А/81 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг үндэслэн хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулж “Есөн хангай аудит” ХХК, “Эс эм аудит” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллав.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 14, төсвийн шууд захирагчийн 115 /ТШЗ-112, ЗГТС-3/ төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 9 нийт 139 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, төсвийн шууд захирагчийн 63, сум хөгжүүлэх сангийн 14, орон нутгийн хөгжлийн сангийн 15 тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж гүйцэтгэлээ.

Аудитаар 124 төсөв захирагчийн тайланд “Зөрчилгүй”, 13 төсөв захирагчийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, 2 төсөв захирагчийн тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзсан.



Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 40,607.9 сая төгрөгийн 972 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 38,220.0 сая төгрөгийн 435 алдааг залруулж, 120.0 сая төгрөгийн зөрчилд 48 төлбөрийн акт тогтоон, 1,775.5 сая төгрөгийн зөрчилд 220 албан шаардлага, 492.4 сая төгрөгийн зөрчилд 262 зөвлөмжийг тус тус хүргүүллээ. Мөн өмнөх оны албан шаардлага хэрэгжүүлээгүй, төлбөрийн актыг барагдуулаагүй, санхүүгийн тайлангийн аудитаар санал дүгнэлт өгөхөөс татгалзсан 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүллээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 14, орон нутгийн төсөвт болон тусгай шилжүүлгийн 133, орон нутгийн өмчит компани 7, тусгай сангийн 29, нийт 183 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн.



Дорноговь аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 133 төсвийн байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 29 тусгай сан, 14 төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан, нийт 183 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 183 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 85 байгууллагыг түүвэрт хамруулж, 98 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Зөрчилгүй” 84, “Хязгаарлалттай” 12 дүгнэлт өгч, Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газар, Замын-Үүд сумын НААҮ ОНӨХХК-ний санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Аймгийн ТЭЗ-ийн Харьяа байгууллагуудын аудитаар нийт 38,996.9 сая төгрөгийн 712 алдаа, зөрчил илрүүлснээс 37,658.8 сая төгрөгийн 293 алдааг залруулж, 114.3 сая төгрөгийн зөрчилд 37 төлбөрийн акт тогтоож, 856.3 сая төгрөгийн зөрчилд 185 албан шаардлага, 367.5 сая төгрөгийн зөрчилд 197 зөвлөмж өглөө.

ТЭЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4 алдаа, зөрчил илрүүлж, 1 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа. Аудитаар илэрсэн зөрчлийг дурдвал:

- *Шилэн дансны цахим системд 8,896.1 сая төгрөгийн 21 захирамжийг мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг мэдээлэх хэсэгт таван сая хүрэхгүй үнийн дүнтэй болон шаардлагагүй гүйлгээнүүдийг мэдээлсэн байна.*
- *Харьяа байгууллагуудын өглөгийн дүн өмнөх оноос өссөн*
- *Арилжааны банк дахь түр дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй.*

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан

Аудитад 14 сумын санхүүгийн нэгтгэсэн тайланг бүрэн хамруулж, 13 төвлөрүүлэн захирагчийн тайланд “Зөрчилгүй”, 1 буюу Замын-Үүд сумын ТТЗ-ийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өглөө.

Аудитаар илэрсэн зөрчлийг ангилан харуулбал:

- *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 707.0 сая төгрөгийн 11 алдаа*
- *Орлого бүрдүүлэлттэй холбоотой 2 зөрчил,*
- *Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой холбоотой 3 зөрчил.*
- *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 17 зөрчил.*

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 710.3 сая төгрөгийн 33 алдаа зөрчил илрүүлж, 707.0 сая төгрөгийн 11 алдааг залруулан, 10 албан шаардлага, 3.3 сая төгрөгийн 12 зөвлөмжийг хүргүүллээ.

Төсвийн шууд захирагчийн тайлан

Аудитад төсвийн шууд захирагчийн 175, сум хөгжүүлэх сангийн 14, орон нутгийн хөгжлийн сангийн 15, ХЭДС, Халамжийн сан-улсын төсөв, Халамжийн сан-орон нутгийн төсөв нийт 207 санхүүгийн тайланг аудитад хамрууллаа. Үүнээс 115 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 92 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэлээ. Тус аудитаар 102 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 12 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Түүвэр аудитад орон нутгийн төсвийн 56, улсын төсвийн 7, орон нутгийн хөгжлийн 15 сан, сум хөгжүүлэх 14 нийт 92 байгууллагыг хамруулахаар төлөвлөн, бүрэн хэрэгжүүлсэн.

Тус аудитаар аймгийн ТЭЗ-ийн харьяаны 13 ТШЗ, улсын төсвийн 1 ТШЗ-ийн тайланд зөрчилтэй дүгнэлт өгснөөс 12 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 2 байгууллагад санал дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Санхүүгийн аудитын тайлангаар 150 ТШЗ-ийн санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллага, 57 ТШЗ-ийн санхүүгийн тайланд хувийн аудитын компани аудит хийж гүйцэтгэсэн.

Төсвийн шууд захирагчийн тайланд 38,510.2 сая төгрөгийн 874 алдаа, зөрчил илрүүлж, 36,239.4 сая төгрөгийн 400 алдааг аудитын явцад залруулж, 120.00 сая төгрөгийн зөрчилд 48 төлбөрийн акт тогтоож, 1,775.5 сая төгрөгийн зөрчилд 200 албан шаардлага хүргүүлж, 375.3 сая төгрөгийн зөрчилд 222 зөвлөмж өгч, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй болон төлбөрийн актыг барагдуулаагүй 5 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан

Аудитад төрийн болон орон нутгийн өмчийн 9 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг хамруулж, 8 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 буюу Замын-Үүд НААҮГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Аудитаар 1,387.4 сая төгрөгийн 60 алдаа зөрчил илрүүлж, 1,273.6 сая төгрөгийн 24 алдааг залруулан, 9 албан шаардлага хүргүүлэн, 113.8 сая төгрөгийн 25 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд өгч, хариуцлага тооцох тухай 2 албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд өгсөн.

Тайлант оны аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ангилан харуулбал:

- *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 4 зөрчил,*
- *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1,202.1 сая төгрөгийн 23 алдаа, 0.7 сая төгрөгийн 8 зөрчил*
- *Дотоод хяналт, худалдан авалттай холбоотой 71.5 сая төгрөгийн 1 алдаа, 113.1 сая төгрөгийн 24 зөрчил.*

ГУРАВ: ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ



Тайлант онд Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан аудитын төлөвлөгөөний дагуу, “Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудит, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 3 аудитыг гүйцэтгэж дууссан.



Аудитаар нийт 29,176.0 сая
төгрөгийн 96 зөрчил



4.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт
15,680.5 сая төгрөгийн 18 албан шаардлага
13,490.8 сая төгрөгийн 76 зөвлөмж

3.1 “Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудит

Аудитад Дорноговь аймгийн ТЕЗ, 14 сумын ТТЗ, аймгийн Татварын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Газрын харилцаа хот байгуулалтын газар, Байгаль орчны газар, ТЕЗ-ийн шууд харьяаны байгууллагуудыг хамруулан орон нутгийн төсвийн төсөлд тусгасан орлого, зарлага, ТАХ-үүдийн тооцоолол үндэслэл, тооцооллыг хууль журмын дагуу хийж үндэслэлтэй төлөвлөсөн эсэхэд аудит хийж гүйцэтгэсэн.

Орон нутгийн төсвийн төсөлд нийт орлогыг 76,530.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 67,997.1 сая төгрөгөөр тооцож, улсын төсөвт 8,783.7 сая төгрөгийг төвлөрүүлж, өмнөх оны үлдэгдлээс 250.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Аймгийн 2023 оны төсвийн орлогын 64.5 хувийг татварын орлогоор, 6.0 хувийг татварын бус орлогоор, 35.4 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлэхээр байна. Харин Орон нутгийн 2023 оны төсвийн суурь зарлагын 53.7 хувийг урсгал зардалд 46.3 хувийг хөрөнгийн зардалд төлөвлөсөн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд нийт 14 зөвлөмжийг аймгийн ТЕЗ, ИТХ-д хүргүүлэв. Аудитаар илэрсэн зөрчлийг товч дурдвал:

- Орон нутгийн төсвийн төсөлд ус, рашаан ашигласны төлбөрийг 277.7 сая төгрөгөөр дутуу тооцоолж тусгасан
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ээс хөрөнгө оруулалтын бус шинжтэй 100.0 сая төгрөгийн төсөвтэй өвс худалдан авах ажлыг оруулсан
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тусгагдсан ТАХ-г үнэлж, хэрэгцээ шаардлагыг нь тодорхойлсон хууль тогтоомжид заасан шалгуур хангаагүй хөрөнгө оруулалтын 12,084.4 сая төгрөгийн 15 ТАХ, их засварын 39.2 сая төгрөгийн 1 ТАХ нийт 12,123.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-г тусгасан
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тусгагдсан ТАХ-г үнэлж, хэрэгцээ шаардлагыг нь тодорхойлсон шалгуур хангасан ажлыг оруулах.
- Автозамын тухай хуульд заасан шаардлагыг хангахгүй замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 989.5 сая төгрөгийн 2 ТАХ-г тусгасан
- ОНХС-аар хийгдэх ажлын зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ зэргийг ирүүлээгүйгээс холбогдох шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлох боломжгүй.
- Аймгийн орон нутгийн төсвийн төсөлд 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгагдаагүй 19 төсөл арга хэмжээг төлөвлөсөн.



Аудитын дүнд үндэслэн “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим төсөл арга хэмжээг хууль, журмын дагуу төлөвлөөгүй байна” гэсэн дүгнэлтийг өгч дарга тэргүүлэх аудиторовн 2022 оны А/34 тушаалаар баталгаажуулав.

3.2. “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудит

Аудитаар аймгийн хэмжээнд 2021 онд улсын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-г хамруулан, 2022.03.01-2022.04.29-ний хугацаанд гүйцэтгэлээ. Аудитын тайланг АГГ-аас өгсөн чиглэлийн дагуу улсын төсөв, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тус тусад нь тайлагнаж “Улсын төсвийн 2021 хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитын тайланг АГГ-т, “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитын тайланг Нийслэл дэх төрийн аудитын газарт тус тус хүргүүлсэн.

Улсын төсөв: Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд Дорноговь аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 62,035.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Үүнээс 31,750.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх 8,500.8 сая төгрөгийн эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлж санхүүжилтийг бүрэн олгосон байна. Эрх шилжсэн 8 төсөл, арга хэмжээнээс 3 нь өмнө оноос шилжиж ирсэн, 5 шинээр эхлэх төсөл, арга хэмжээ байна. Төсөл, арга хэмжээг төрлөөр нь авч үзвэл 80 хувь нь барилга байгууламж барих, 20 хувь нь бусад хөрөнгө оруулалтын ажил байна.

Орон нутгийн төсөв: Дорноговь аймгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар 13,901.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 9,290.7 сая төгрөгийн батлагдаж 8,150.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

УТХО-аар нийт 3,203.4 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс 3,203.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 4 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. ОНХО-аар нийт 3,396.2 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс 3391.4 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд албан шаардлага, 4.8 сая төгрөгийн 1 алдаа зөрчилд 2 төлбөрийн акт, 5 зөвлөмжийг хүргүүлсэн. Аудитаар илэрсэн зөрчлийг товч дурдвал:

- Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус ажил төлөвлөж хэрэгжүүлсэн
- Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүйгээс чанаргүй хөрөнгө, засвар үйлчилгээ нийлүүлэгдсэн, бодит гүйцэтгэлийг хянаагүй, гэрээний дүнгээс илүү мөнгө
- Хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэлд бүрэн тусгаагүй
- Зохиогчийн хяналтыг гэрээний дагуу бүрэн хийгээгүй
- Аймгийн Засаг даргын дотоод аудитын нэгж улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлээгүй
- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөсөн.

Аудитын дүнд үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтад “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөлт хяналтын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна”, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо бүрдээгүй байна” гэсэн дүгнэлтийг өгч, дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны А/08 дугаар тушаалаар баталгаажуулав.



3.3 “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудит

Аудитад Дорноговь аймгийн ИТХ, аймаг, сумдын ЗДТГ, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Политехникийн коллеж, Төмөр замын МСҮТ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, мэргэжилтэн бэлтгэх чиглэлээрх 2016-2021 онуудын үйл ажиллагааг хамруулж 2022.03.01-2022.05.05-ны өдрийн хооронд гүйцэтгэв.

СХС, ХЭДС, ЖДҮДС-аас аудитад хамрагдсан онуудад жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 7,730.4 сая төгрөгийг 846 төсөл хэрэгжүүлэхэд зарцуулжээ. Төслийн үр дүнд нийт 1,429 ажлын байрыг хадгалах болон шинээр бий болгосон байна. Үүнээс 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 993 ажлын байр буюу 69.5 хувь нь хадгалагдан үлдсэн байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд нийт 4 зөвлөмжийг холбогдох 3 албан тушаалтанд хүргүүлэв. Аудитаар илэрсэн зөрчлийг товч дурдвал:

- Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл хууль тогтоомжид заасан зарим чиг үүргийг хэрэгжүүлээгүй
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнд шаардагдах төсвийн тооцооллыг боловсруулаагүй, санхүүгийн эх зарим үүсвэрийг оновчгүй тодорхойлсон
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2016-2021 онд ХЭДС-аас 68.9 сая төгрөг зарцуулсан ба хамрагдсан иргэдийн тоо мэдээг зөрүүтэй, үнэн зөв тайлагнаагүй улмаас үр ашгийг тооцох боломжгүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгө, ХБИАТ, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг үндэслэлтэй төлөвлөөгүй.

Аудитын дүнд үндэслэн “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээ нь урт хугацаанд тогтвортой ажлын байрыг бий болгоход чиглэгдэж чадаагүй байна” гэсэн дүгнэлтийг өгч дарга тэргүүлэх аудиторовн 2022 оны А/12 дугаар тушаалаар баталгаажуулав.

3.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт аудит

Аудитад аймаг, сумдын 15 ИТХ, аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, аймаг, сумдын 15 орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны үйл ажиллагааг хамруулж 2022.04.21-2022.06.03-ны өдрийн хооронд гүйцэтгэв.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС-аас Дорноговь аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 19,069.5 сая төгрөгөөр баталж, 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн төсвийн нэмэлт өөрчлөлтөөр 266.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 19,336.3 сая төгрөгөөр баталсан байна. “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс 2021 онд 107.1 сая төгрөгийн дэмжлэг, 301.8 сая төгрөгийн урамшуулал олгохоор баталжээ.



Өмнөх оноос шилжиж ирсэн 39, тайлант онд хэрэгжүүлэх 155, нийт 194 төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн 40.8 хувийг барилга байгууламж, дэд бүтэц, засварын ажил, 30.6 хувийг тоног төхөөрөмж, камержуулалт, гудамжны гэрэлтүүлэг, 14.6 хувийг жишиг гудамж, тоглоомын талбай, зураг төсөв, 14.0 хувийг өвс, худаг усны ажил эзэлж байна. Санхүүжилт олгосон байдлыг авч үзвэл сумдын ОНХС-д нийт 8,190.8 сая, тохижилт үйлчилгээний зардалд 59.1 сая, мал эмнэлгийн үйлчилгээний зардалд 148.8 сая, аймгийн ОНХС-д 10,937.6 сая төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

Аудитаар нийт 2,753.3 сая төгрөгийн 59 зөрчил илрүүлж, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх, дутуу ажлыг гүйцэтгүүлэх, хөрөнгө данс бүртгэлд бүртгэх зэрэг нийт 2,753.3 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, холбогдох албан тушаалтнуудад 47 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Аудитаар илэрсэн зөрчлийг товч дурдвал:

- Орлогын эх үүсвэрийг бүрэн тооцоолж төлөвлөөгүй
- Иргэдээс санал авч эрэмбэлээгүй ажлыг ИТХ баталсан, санхүүжүүлсэн
- Зураг төсөвгүй ажил батлан дараа нь зураг төсөв хийлгэсэн
- Худалдан авах ажиллагаанд иргэдийн төлөөллийг оролцуулаагүй
- Гэрээний хугацаа өнгөрсөн байхад алданги тооцоогүй
- Тухайн шатны ИТХ хяналт бүрэн хэрэгжүүлээгүй
- Захиалагчийн хяналтыг хууль журмын дагуу хэрэгжүүлээгүй
- Хэрэгжсэн хөрөнгө оруулалтыг бүртгэлд бүрэн тусгаагүй
- Удирдлагын мэдээллийн системийн ашиглалт хангалтгүй
- ОНХС-аар хэрэгжих ажил бүрэн хэрэгжээгүй.

Аудитын дүнд үндэслэн **“Сангийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөн нэмэгдүүлж, арга хэмжээний гүйцэтгэл, хяналтын үр дүнг дээшлүүлснээр орон нутгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг сайжруулах боломжтой байна”** гэсэн дүгнэлтийг өгч дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны А/15 дугаар тушаалаар баталгаажуулав.

ДӨРӨВ: НИЙЦЛИЙН АУДИТ



Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-д нийцлийн аудит батлагдаагүй.

ТАВ: БУСАД АУДИТ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

5.1 Бусад аудит



Тайлант онд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны 105 тушаалаар батлагдсан журмын “Үйл ажиллагааны тайлан, бүтэц” хэсгийн 5.2.1-т заасны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-д заасны дагуу өөрийн санаачилгаар хийх 2 гүйцэтгэлийн аудит, өмнөх оноос шилжиж ирсэн 1 нийцлийн аудит тус тус гүйцэтгэсэн. Мөн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/34 дүгээр тушаалаар батлагдсан нэмэлтээр хийх 3 аудитыг гүйцэтгэн баталгаажуулж холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлээ.

5.1.1 “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудит

Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, холбогдох төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, аймгийн хэмжээнд АЗЗА ТӨХК, Чандмань-Илч ОНӨХХК, Замын-Үүд НААҮ, Дагшин-Эрдэнэ, Борхойн баян бүрд ОНӨААТҮГ-ын 2019-2021 оны үйл ажиллагаа үйл ажиллагааг хамруулсан.



Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн.

Аудитаар нийт 2,993.4 сая төгрөгийн 8 зөрчил илрүүлж, зөрчил арилгах талаар 1 албан шаардлага, алдааг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтнуудад 7 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Аудитаар илэрсэн зөрчлийг товч дурдвал:

- Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан засаглалыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх эрх, үүрэг тодорхой бус байгаагаас аймгийн бодлогын баримт бичигт тусгаж хэрэгжүүлээгүй.
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ нь ОНӨХЭ-ийн хуулиар тогтоосон жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах үүргийг орхигдуулсан
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд зорилтот түвшнийг үр дүнд чиглэсэн, ашигтай байдлаар төлөвлөөгүй.
- Замын-Үүд НААҮ ОНӨААТҮГ нь 2021 оны зорилтот түвшнийг батлуулахгүй үйл ажиллагаа явуулсан.
- Зорилтот түвшин, дунд болон урт хугацааны төлөвлөлтийг үр ашигтай төлөвлөхөд санхүүгийн үйл ажиллагаа болон тайланд үр ашгийн тооцоо, шинжилгээг үндэслээгүй.

Аудитын дүнд үндэслэн “Санхүүгийн үйл ажиллагаанд тооцоо шинжилгээ хийж зорилтот түвшинг бодитой төлөвлөснөөр үр ашгийг дээшлүүлэх боломж байна” гэсэн дүгнэлтийг өгч дарга, тэргүүлэх аудиторовын 2022 оны А/19 тушаалаар баталгаажуулав.

5.1.2 “Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт, усны нөөцийн ашиглалт” сэдэвт гүйцэтгэлийн аудит.

Өөрийн санаачилгаар хийх тус аудитад уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт, усны нөөцийнашиглалтын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, тайлагнал болонБайгаль орчин, аялал жуулчлалын газар, аймаг, сумын ИТХ, ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 2020-2021 оны үйл ажиллагааг хамруулан 2022.06.10-2022.09.30-ны өдрийн хооронд гүйцэтгэлээ.

Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт, усны нөөцийн ашиглалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмжболовсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Дорноговь аймагт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 215 ААНБ-д 67.2 мянган га газар, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 127 ААНБ-д 835.7 мянган га газар нийт 1,102.9 мянган га талбайд 342 зөвшөөрөл байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 10.1 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд ашигт малтмал олборлогч иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд оржнөхөн сэргээлт хийгээгүй орхигдсон 13 сумын 148 байршилд байрлах 3,545 га газрыг бүртгэж, 7.3 тэрбум төгрөгөөр нөхөн сэргээх тооцоо гарсан байна. Аймгийн 2021 оны статистикмэдээгээр 3285 худаг байгаагаас инженерийн хийцтэй 640 худаг, энгийн уурхайн 2645 худаг тоологдож, бүртгэгдсэн байна.

Аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг арилгаж таслан зогсоох 7 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх цаашид анхаарч ажиллах тухай 14 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв. Аудитаар илэрсэн зөрчлийг товч дурдвал:

- Аймгийн хэмжээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий 339 ААНБ-аасдавхардсан тоогоор 155 компани байгаль орчны менежментийн төлөвлөгөөгбатлуулснаас 51 ААНБ нөхөн сэргээх арга хэмжээг тусгаагүй байна.
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах ажил хийгдээгүй байна.
- Аймгийн хэмжээнд уул уурхайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 339 ААНБ-аас 4 сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 8 компани аймаг, сумдын Засаг даргатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна.
- Аймгийн Цагдаагийн газарт газрын хэвлийд халдаж хууль бусаар ашигтмалтмал олборлосон нийт 23 хэрэг бүртгэгдсэнээс 2 хэрэгт торгуулийн ял, 3 хэргийг тэнсэн харгалзах ялаар шийтгэж, 1 хэргийг цагаатган, 6 хэргийг прокурорын газраас хааж, өнөөдрийн байдлаар 10 хэрэг шийдвэрлэгдээгүй байгаа ба хэргийн шийдвэрлэлтээс харахад хууль бусаар газрын хэвлийд халдаж учруулсан хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх арга хэмжээ орхигдсонбайна.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн зардлын 50 хувь болох 98.6 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг нөхөн сэргээлтийн санд байршуулаагүй байна.
- Сумдын НСС-д байршуулсан байгаль хамгаалах, нөхөн сэргээх барьцааны орлогоос 83.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Мэргэжлийн байгууллагууд болон орон нутгийн удирдлагаас байгаль орчныхамгаалах болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах хяналтыгбүрэн хэрэгжүүлээгүй, хяналт шалгалтаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.
- Ус ашиглагч ААНБ-уудтай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.
- Зарим ААНБ нь усыг зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээ авчажиллахгүй байна.
- Хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Аймгийн МХГ нь хяналт шалгалт хийж байгаа үр дүн хангалтгүй, зөрчилдавтагдсан хэвээр байна.

Аудитын дүнд үндэслэн “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-ын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна” гэсэн дүгнэлтийг өгч дарга тэргүүлэх аудиторын 2022 оны А/30 дугаар тушаалаар баталгаажуулав.

5.1.3 “Газрын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудит.


Өмнөх оноос шилжиж буй тус аудитад Аймгийн ИТХ, Аймгийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2019-2021 оны үйл ажиллагааг хамруулан 2022.05.02-2022.07.10-ны өдрийн хооронд гүйцэтгэлээ.

Газрын тухай хуулийн хэрэгжилт, үр дүнг үнэлж аудит хийн, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дорноговь аймаг нь нийт 10,947,230 га газар нутагтай үүний 9,385,289.7 га буюу 85.7 хувь нь хөдөө аж ахуйн газар, 187,385.1 га буюу 1.7 хувь нь хот тосгон, бусад суурин газар, 62,695.5 га буюу 0.6 хувь нь зам шугам сүлжээний газар, 158,519.7 га нь буюу 1.4 хувь нь ойн сан бүхий газар, 27,765.5 га буюу 0.3 хувь нь усан сан бүхий газар, 1,125,574.5 га буюу 10.3 хувь нь улсын тусгай хэрэгцээний газар эзэлж байна. Аймгийн хэмжээнд 2021 оны байдлаар 779,562.9 га газрыг иргэн, ААНБ-ын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгосон байна. Үүнээс 596,842.4 га газрыг эзэмшиж, 179,491.5 га газрыг ашиглаж байна.

Аудитаар илрүүлсэн алдаа зөрчил 1.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгаж таслан зогсоох 4 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид анхаарч ажиллах тухай 7 зөвлөмжийг 3 албан тушаалтанд хүргүүлэв. Аудитаар илэрсэн зөрчлийг товч дурдвал:

- Өргөн, Даланжаргалан, Айраг сумд газар зохион байгуулалтын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулаагүй байна.
- Газар зохион байгуулалтын үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөгүйгээс тухайн жилийн төлөвлөгөө нь ГЗБЕТ-тэй уялдахгүй байна.
- Газар зохион байгуулалтын тухай жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд 2.4 га газрыг шууд олгосон байна.
- Гэр бүлийн хамтын хэрэгцээний зарим газрыг хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн, үнэ төлбөргүй олгосон байна.
- Гэр бүлийн хамтын хэрэгцээний газрыг 14 иргэнд давхардуулан олгосон байна.
- Газрын зарим дуудлага худалдаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй байна.
- Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр улсын тусгай хэрэгцээний газарт сууришлын бүс үүсгэсэн байна.
- Зарим газарт хууль тогтоомжид заасан төлбөрийг ногдуулаагүй байна.
- Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй 50 ААНБ-ын 113,061.3 га газрын ашиглах эрхийг баталгаажуулаагүй байна.
- Газрын зориулалтыг өөрчлөхөд баримтлах шалгуур, нөхцөл байхгүй байна.
- Зарим иргэн, ААНБ газрын зориулалтыг дур мэдэн өөрчилж, эзэмшиж, ашиглаж байна.
- Сайншианд, Замын-Үүд сумдад хүндэтгэн үзэх шалтгаангүй 2 жил ашиглаагүй 345.2 га газар байна.
- Аймаг, сумдын ИТХ болон МХГ нь газрын тухай хуульд заасан үүргээ бүрэн биелүүлээгүй байна.



Аудитын дүнд үндэслэн **“Хэсэгчилсэн төлөвлөгөө байхгүйгээс тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах боломжгүй байна”** гэсэн дүгнэлтийг өгч дарга тэргүүлэх аудиторын 2022 оны А/20 дугаар тушаалаар баталгаажуулав.

5.1.4 “Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох бие даагч, нам эвслийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах” сэдэвт аудит.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.16-д “ТАБ-аас 2022 онд нэмэлтээр хийх, төлөвлөгөөт бус аудитыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх” ажлын хүрээнд МУЕА-ын 2022 оны А/34 дүгээр “ТАБ-ын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай” тушаалын дагуу тайлант хугацаанд “Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох бие даагч, нам эвслийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах” аудитыг хийж гүйцэтгэлээ

Аудитаар аймгийн 1, сумын 1 тойргийн сонгуульд оролцох 2 нам нь намын мөрийн хөтөлбөр хандивын тайланд дүгнэлт гаргуулахаар албан бичгээр мөрийн хөтөлбөр хандивын тайлангаа ирүүлсэн. Тус 2 намын аймаг, тухайн сумын мөрийн хөтөлбөр хандивын тайланд дүгнэлт гарган хуулийн хугацаанд багтаан 2022.04.18-ны өдрийн 1-6/384-392 албан тоотойр нам болон аймгийн сонгуулийн хороонд хүргүүлсэн.

Аудитаар тус 2 нам эвслийн тайлан нь 2020 оны ээлжит сонгуулийн хөтөлбөрөөс зөрүүгүй хуучин мөрийн хөтөлбөрөөр оролцсон. Мөн тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив байхгүй байсан.

5.1.5 “Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийх аудит” сэдэвт аудит.

Монгол Улсын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журамд заасны дагуу аймаг, сумын хурлын нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорноговь аймгийн сонгуулийн хорооны зардлын тайланд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасныг баримтлан МУЕА-ын 2022 оны А/34 дүгээр тушаал, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн.

Орон нутгийн хурлын нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорноговь аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлангийн төлөвлөлт, зарцуулалтад дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аймгийн сонгуулийн хороонд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитыг орон нутгийн нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд хуваарилан зарцуулсан төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой баримт материалуудыг хамруулан авч үзлээ.

Орон нутгийн нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс аймгийн сонгуулийн хороонд 50.8 сая төгрөгийг хуваарилсан байна. Дорноговь аймгийн сонгуулийн хороо болон Улаанбадрах, Иххэт сумдын сонгуулийн хороо, 5 хэсгийн хороод 59 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Аймгийн Сонгуулийн хороонд нийт 50.8 сая төгрөгийг СЕХ-ноос хуваарилснаас гүйцэтгэлээр нийт 49.1 сая төгрөгийг зарцуулж, 1.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос орон нутгийн хурлын нөхөн сонгууль зохион байгуулах зардалд улсын төсвөөс 50.8 сая төгрөгийн санхүүжилт олгосныг аймаг, сумдын сонгуулийн хороод Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын холбогдох заалтын дагуу зарцуулж, тайлагнасан байна.

5.1.6 “Орон нутгийн хурлын нөхөн сонгуульд оролцох нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх” сэдэвт аудит.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, АНСДИТХСТ хуулийн 57 дугаар зүйл, МҮЕА-ын 2022 оны А/34 дүгээр тушаал, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийжгүйцэтгэлээ. Аудитад аймаг, сумын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийг хамруулсан.

Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалтын тайланг хянаж, дүгнэлт гаргах, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэхэд оршино.

Орон нутгийн Хурлын 2022 оны нөхөн сонгуульд оролцсон намууд нь сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 1,456.0 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 1,356.0 мянган төгрөг, бусад зардалд 100.0 мянган төгрөг, нэр дэвшигчид сонгуулийн зардалд 3,057.0 мянган төгрөг, бусад зардалд 485.0 мянган төгрөг, нийт 4,998.0 мянган төгрөгийг тус тус зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нам, нэр дэвшигчдийн сонгуульд зарцуулах хөрөнгийн санхүүжилтэд иргэн, хуулийн этгээдээс авсан хандив байхгүй эх үүсвэрийг өөрсдийн хөрөнгөөр бүрдүүлсэн байна.

5.2 Үүрэг даалгаврын биелэлт

МҮЕА-ын 2022 баталсан тушаалаас өөрийн байгууллагад хамаарах 20 тушаалын хэрэгжилтийг бүрэн хангаж тайланг ЗХЭЗГ-ын захиргааны шинжээч М.Номиндарьд 2022.12.09-ний өдөр цахим хаягаар, Удирдлагын шуурхай хуралдаанаас нэгжид өгсөн 3 үүрэг даалгаврын хэрэгжилт, Удирдах ажилтны зөвлөгөөнөөс нэгжид өгсөн 12 үүрэг даалгаврын хэрэгжилт, АНТАГ-ын цахим хуралдаанаар нэгжид өгсөн 9 үүрэг даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангаж тайланг ДАХШҮ-ний ахлах аудитор Ө.Сарантуяад 2022.12.16-ны өдөр цахим хаягаар хүргүүлсэн.

МҮЕА-ын 2022 онд баталсан тушаалын хэрэгжилт

/Хүснэгт №6/

№	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар	АНТАГ-т хамаарах тушаалын тоо	Хэрэгжилтийн хувь
1	Монгол улсын Ерөнхий аудиторовн баталсан "А" тушаал	20	100%
2	Удирдлагын шуурхай хуралдаанаас нэгжид өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	3	100%
3	Удирдах ажилтны зөвлөгөөнөөс нэгжид өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	12	100%
4	АНТАГ-ын цахим хуралдаанаар нэгжид өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	9	100%
Нийт		44	100%

ЗУРГАА: ДОТООД АЖИЛ



Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг дэмжих дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

6.1 Дотоод сургалт:

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг албан хаагчдаас ирүүлсэн сургалтын санал, хэрэгцээ шаардлага болон ҮАГ-ын сургалтын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, дарга, тэргүүлэх аудитораар батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус төлөвлөгөөнд байгууллагын албан хаагчдаас зохион байгуулах 12 сургалт, сургалтын мэргэжлийн байгууллага, багштай хамтран зохион байгуулах 5 сургалтыг тусгасан.

Өмнөх онд тус газрын албан хаагчдын 30 гаруй хувь шинэчлэгдсэнтэй холбоотойгоор сургалтыг ихэвчлэн аудитын стандарт, онолд чиглүүлж явуулсан бол тайлант онд аудитын заавар, аргачлал, практик хэрэглээ, хувь хүний хөгжил болон байгууллагын уур амьсгал, сэтгэл зүйтэй холбоотой сургалтыг түлхүү явуулахаар төлөвлөсөн.

Дотоод сургалтын төлөвлөгөөнд 17 сургалтын 11 сургалт нь аудитыг шууд гүйцэтгэхтэй холбоотой, 6 сэдэв нь хувь хүнийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт байна. Сургалт бүрд 11-13 албан хаагч хамрагдаж, давхардсан тоогоор 17 сургалтад 193 албан хаагч хамрагдсан. Дотоод сургалтыг төлөвлөгөөний дагуу бүрэн зохион байгуулсан. Үүнд:

- “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал” /МУЕА-ын 2021 оны А/70 дугаар тушаал/
- “Төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтын хэрэглээ”
- “ХАСХОМ мэдүүлэх тухай”
- “Хувь хүний хөгжлийн сургалт” /харилцаа, хамт олны уур амьсгал, ажлын идэвхжүүлэлт, багаар ажиллах чадвар/
- “Хувь хүний хөгжлийн сургалт” /ажлын цаг ашиглалт/
- “Хүүхдийн хүмүүжил” /гадны байгууллагатай хамтарсан сургалт ГБХЗХГ/
- “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал” /МУЕА-ын 2021 оны А/70 дугаар тушаал/
- Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал /МУЕА-ын 2021 оны А/69 дүгээр тушаал/
- Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалын практик хэрэглээ
- Аудитын үр өгөөжийг төлөвлөх бүртгэх, тайлагнах
- Аудитын тайлан, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж боловсруулах
- Нийцлийн аудитын заавар, аргачлал /МУЕА-ын 2021 оны А/69 дүгээр тушаал/
- Нийцлийн аудитын заавар, аргачлалын практик хэрэглээ
- 2022 оноос шинээр мөрдөгдөж эхэлсэн хууль тогтоомж, журмын танилцуулга
- Монгол бичгийн мэдлэг олгох сургалт /Насан туршийн боловсролын багш М.Бондгор/
- Гэр бүлийн харилцаа хүүхдийн хүмүүжил /ГБХЗХГ-ын мэргэжилтэн/
- Монгол хэлний зөв бичих дүрмийн сургалт /Насан туршийн боловсролын багш М.Бондгор/
- Статистик дүн мэдээ нэгтгэх, мэдээлэл цуглуулах, боловсруулах арга /Статистикийн хэлтсийн дарга Х.Өлзийсүрэн/
- Байгууллагын сэтгэл зүй /Ахмад ажилтан Ц.Лүндэгмаа/



Сургалтад ашиглагдсан материал, слайд, сургалт явуулах бүрд батлуулсан төлөвлөгөө, үнэлгээ, ирцийн баримт материалыг тухай бүр сургалт явуулсан албан хаагчдаас сургалт хариуцсан ажилтан цаасаар авч, дотоод сургалтын архивын нэгжийг жил бүр үүсгэн ажиллаж хэвшсэн.

ҮАГ-аас зохион байгуулсан “Нэгдсэн сургалт-2022” бүсчилсэн сургалтаар заасан хичээлийн сэдэв нь тус газрын сургалтын сэдэвтэй давхардсан тул 5 болон 6 дугаар сард явуулах хичээлийн агуулгад өөрчлөлтөд оруулж, 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөж байна.

Байгууллагын албан хаагчид мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилгоор дотоод сургалтаас гадна дараах сургалтад хамрагдаад байна. Үүнд:

ҮАГ-аас зохион байгуулсан ТАБ-ын байгууллагын албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх 24 цагийн “Нэгдсэн сургалт-2022” бүсчилсэн цахим сургалтад 11 албан хаагч хамрагдаж, амжилттай суралцсан.

ТАБ-ын сургалт, хөгжлийн системд байршуулсан дараах сургалтад хамрагдсан. Үүнд:

- ✓ “Хуулийн хэрэглээ /Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга/” сэдэвт цахим сургалтад 2 албан хаагч хамрагдаж, амжилттай суралцсан.
- ✓ “Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ” сэдэвт цахим сургалтад 3 албан хаагч хамрагдсан.
- ✓ “Төрийн албан хэрэг хөтлөлт” сэдэвт е-хичээлд 11 албан хаагч хамрагдан, суралцаж шалгалтаа амжилттай өгсөн
- ✓ “Төрийн аудиторын ёс зүй” сэдэвт е-хичээлд 11 албан хаагч хамрагдан, суралцаж шалгалтаа амжилттай өгсөн.
- ✓ “Аудитын үйл ажиллагааны иргэдийн оролцоо” сэдэвт е-хичээлд 11 албан хаагч хамрагдан, суралцаж шалгалтаа амжилттай өгсөн.

ТАБ-ын 2022 оны зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу аудитын нэгдүгээр газрын менежер Ж.Батсайханы явуулсан “Чанарын хяналт болон нэгдсэн удирдлага хоёрын харилцан уялдаа, цаашдын чиг хандлага”, “Аудитын чанарын хяналтын тогтолцоо” сэдэвт сургалтад аудиторууд бүрэн хамрагдсан.

Үүнээс гадна, ҮАГ-аас зохион байгуулсан шилэн дансны цахим систем болон санхүүгийн тайлангийн аудитын системийн тухай ойлголт, шинээр батлагдсан хууль, дүрэм, журмын танилцуулгын талаарх мэдээлэл өгөх сургалтуудад байгууллагын бүх албан хаагчид хамрагдсан болно.

6.2 Архив, бичиг хэрэг:

Архив, албан хэрэг хөтлөх ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ.

- Тайлант онд нийт 775 албан бичиг ирж, бусад байгууллага албан тушаалтанд 771 албан бичгийг хүргүүлсэн байна.
- Байгууллагын үйл ажиллагаа болон хүний нөөцтэй холбоотой “А” тушаал 38, “Б” тушаал 14 тус тус гарсан байна.
- Ирсэн болон явсан бичгийн хариу ирүүлэх хугацааг ABLE программд тэмдэглэж, хяналт тавин ажиллаж байна.
- Ирсэн болон явсан бичгийг бичиг хэргийн ажилтан тухай бүр сканердаж, цахим сан /архив/ үүсгэж байна.
- Байгууллагын албан хэрэг хөтлөх үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэх зорилгоор ББНШК хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, аймгийн Архивын газраар батлуулсан.
- Байгууллагын байнга хадгалагдах 2003-2015 оны архивын нэгжүүдийг төрийн архивд бүрэн шилжүүлсэн.

6.3 Өргөдөл, гомдол шийдвэрлэлт:

Тайлант онд байгууллагын алба хаагчдаас нийт 17 өргөдөл ирүүлж, бусад байгууллага, иргэнээс өргөдөл гомдол ирээгүй. Албан хаагчдаас ирүүлсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэхээр ирүүлсэн.

- Чөлөө хүссэн 14,
- Зэргийн нэмэгдэл авах тухай 2,
- Буцалтгүй тусламж хүссэн 1

Албан хаагчдаас ирүүлсэн өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллалаа. Шийдвэрлээгүй болон хугацаа хоцорсон өргөдөл гомдол байхгүй.

6.4 Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа:

Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг ханга чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

- “Нэгдсэн сургалт-2022” сургалтын хүрээнд сургалтын техникийн бүрэн байдал цаашид ажлын нөхцөлийг сайжруулах чиглэлээр 5 аудиторууд *notebook*-р хангасан.
- Жил бүр тохиох Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр байгууллагын албан хаагчдын үр хүүхдүүдэд бэлэг гардуулж занисан ба тайлант оны 6 дугаар сарын 1- ний өдөр албан хаагчдын 24 хүүхдэд бэлэг гардуулсан.
- Байгууллагын албан хаагчдын чөлөөт цагийг зөв, үр бүтээлтэй өнгөрүүлэх үүднээс 7 хоног бүрийн нүрвэ гарагт гар бөмбөг, сагсан бөмбөгийн спортоор хичээллэж байна.
- Ковид-19 цар тахлын тархалт ихэссэн хүнд үед албан хаагчдыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Верацелл вакциныг 3 тунд хамруулж, ажиллаад байна.
- Улсын хэмжээнд зохион байгуулж буй цахим гарын үсэг олгох үйл ажиллагааны хүрээнд Улсын бүртгэлийн албан хаагчийг байгууллагадаа авчран нэгдсэн журмаар бүх албан хаагчийг цахим гарын үсэгтэй болсон. Ингэснээр цахимаар гэрээ байгуулах, баталгаа гаргах боломжтой болсон.
- Тайлант хугацаанд аудиторууд ачаалал ихтэй ажилласан тул илүү цагийн хөлсийг журмын дагуу тооцож олгосон.
- Шинэ хүүхэдтэй болсон аудитор Б.Ариунбаатарт хагас сарын цалинтай тэнцэх мөнгөн тусламж олгосон.

6.5 Хүний нөөц, шагнал урамшуулал, амжилт, харилцаа, хамтын ажиллагаа

Хүний нөөц, шагнал урамшуулал: Тайлант онд албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж, амжилттай ажилласан зарим албан хаагчийг орон нутгийн захиргааны байгууллага болон ТББ-ын шагналт тодорхойлон шагнууллаа. Үүнд:

- “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар аудитын менежер У.Оюунтүлхүүр
- “Төрийн хяналтын тэргүүн” цол тэмдгээр дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-өлзий, Ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Б.Уранбилэг, Ч.Хэрлэнчимэг
- “Ардын хувьсгалын 100 жил”-ийн ойн медалиар жолооч Ч.Батцэнгэл
- Аймгийн 90 жилийн ойн медалиар дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-өлзий, аудитын менежер У.Оюунтүлхүүр, ахлах аудитор Э.Энхцэцэг аудитор Б.Уранбилэг, Ч.Хэрлэнчимэг
- Сайншианд сумын 60 жилийн ойн медалиар ахлах аудитор Т.Мөнхтогтох, Л.Равдандорж, аудитор Б.Ариунбаатар, Б.Алтанзул, М.Дүүрэнжаргал, Д.Дэмбэрэлсүрэн.
- Аймгийн ИТХ-ын өргөмжлөлөөр аудитын менежер У.Оюунтүлхүүр, жолооч Ч.Батцэнгэл, Ч.Хэрлэнчимэг
- Сайншианд сумын ИТХ-ын өргөмжлөлөөр аудитор Т.Мөнхтогтох
- Сайншианд сумын Засаг даргын өргөмжлөлөөр аудитор Б.Уранбилэг.

Хүний нөөцийн ХНУМС шинэчлэгдсэн системд нийт 13 алба хаагчийн мэдээллийг бүрэн оруулсан. Хүний нөөцийн өөрчлөлттэй холбоотой мэдээллийг системд тухай бүр шинэчлэн ажиллаж байна.

Төрийн хяналтын байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээ: Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газраас зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган байгууллагын дарга, тэргүүлэх аудитораар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Тус төлөвлөгөөнд тусгагдсан аймгийн төсөв захирагчид болон санхүүгийн ажилтнуудын дунд зохион байгуулах гар бөмбөг, танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг 2022 оны 06 дугаар сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Тэмцээн зохион байгуулах зардал болон шагналын санг байгууллагын хамтын сан, баг тамирчдын оролцооны зардлаар зохион байгуулсан.

Гар бөмбөгийн тэмцээнд аймаг, сумдын төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын төсөв захирагч, санхүү бүртгэлийн ажилчдаас бүрдсэн 11 баг өрсөлдөж, тэргүүн байранд Алтанширээ сумын баг, дэд байранд Төрийн аудитын баг, гутгаар байранд аймгийн Төрийн сан, Татварын хэлтсийн хамтарсан баг тус тус шалгарч медаль өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.



Төрийн хяналтын байгууллагын түүхэн замнал, төрийн аудитын байгууллагын хууль, эрхзүйн орчин, үйл ажиллагааг сурталчлан таниулах, ерөнхий мэдлэг шалгах зорилгоор иргэдийн дунд зохион байгуулсан танин мэдэхүйн “АХА” тэмцээнд төсвийн байгууллагын ажилчид болон иргэдээс нийт 31 хүн оролцож, өөрийн мэдлэг чадвараараа тэргүүлсэн 2 оролцогчийг шалгаруулсан.

Тэмцээний тэргүүн байрыг Алтанширээ сумын ИТХ-ын дарга Б.Ган-Од, удаах байрыг Даланжаргалан сумын ЗДТГ-ын нягтлан бодогч Б.Бат-Оюун эзэлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.

Мөн Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд тус аймгийн Төрийн аудитын байгууллагад ажиллаж байсан ахмадууд үе үеийн удирдлагууд, ажилчид, хамт олноо хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн. Энэхүү хүндэтгэлийн арга хэмжээний үеэр төрийн хяналтын байгууллагын 100 жилийн ойн баримтат киноны зураг авалт, бичлэг хийгдсэн.



Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд байгууллагын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “100 жил-100 бэлэг” арга хэмжээг зохион байгуулж, Эх үрсийн баярын өдрөөр 100 хүүхдэд бэлэг гардуулж баярлууллаа. Энэхүү арга хэмжээг мөн байгууллагын хамтын сангийн хөрөнгөөр зохион байгуулсан.

“Байгууллагын нээлттэй өдөр” арга хэмжээг 2022.12.07-ны өдөр хийж төсөвт болон ТБОНӨ-ийн оролцоот байгууллагуудын төсөв захирагч, нягтлан бодогч нийт 78 хүн хамрагдсан. Үйл ажиллагаанд дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий ТАБ-ын тухай ойлголт, түүхэн замнал, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын талаарх танилцуулгыг хийж оролцогчдын сонирхсон асуултад хариулсан. Арга хэмжээний үеэр байгууллагын мэндчилгээтэй сонин, санхүүгийн тайлангийн болон шууд тайлагнах аудитын танилцуулга тараах материалыг тараасан.



Орон нутгийн сонин хэвлэлд Баярын мэндчилгээ нийтлүүлэх ажлын хүрээнд: “Өнөөгийн Дорноговь” орон нутгийн сонины 2022 оны 19 дугаарт байгууллагын түүхэн хөгжил танилцуулга мэндчилгээг бэлтгэн хэвлүүлсэн.



Дорноговь Төрийн аудитын байгууллагын түүхэн товхимол бэлтгэх ажлын хүрээнд: Байгууллагын түүхэн товхимол номыг бүрэн боловсруулан хэвлүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “10 сая мод” арга хэмжээнд нэгдэж, аймгийн шинээр байгуулагдаж буй цэцэрлэгт хүрээлэнд ахмад ажилтнуудтайгаа хамтран мод тарьж нэг өдрийг хамтдаа өнгөрүүлээ.



Ажилчдын ажиллах урам зориг, хамт олны уур амьсгалыг эерэг байлгах үүднээс улирал бүр хамт олны дунд уралдаан тэмцээн зохион байгуулахаар төлөвлөсний дагуу 2022



оны 1 дүгээр улиралд сар шинийн баярыг тохиолдуулан захиргаа удирдлагын багаас “Монгол найдгай” арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд албан хаагчдыг 4 баг болгон шагай няслах, морь уралдуулах, шагай шүүрэх, сээр шалгах тэмцээнийг зохиож тэмцээнд багийн дүнгээр АХН түрүүлсэн. Мөн 2022 оны 2 дугаар улиралд АГН-ээс “Спортлог хамт олон” арга хэмжээг зохион байгуулан “Сагсан бөмбөг”, ширээний теннис, дартсын 3 төрлөөр тэмцээнийг 4

багийн дунд явуулж АХН түрүүлсэн. Түрүүлсэн тэмцээн тус бүрээр мини цом гардуулан багийн дүнгээр түрүүлсэн багт бэлэг дурсгалын зүйл гардууллаа.

Амжилт, харилцаа. хамтын ажиллагаа:

Аймгийн болон Замын-Үүд сумын Прокурорын байгууллагатай хамтран ажиллах санамж бичгийг байгуулан, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйл, Төрийн аудитын байгууллагаас тогтоосон хэрэгжихгүй байгаа төлбөрийн акт, албан шаардлагыг барагдуулах хамтран ажиллахаар болсон. Санамж бичгийн хүрээнд хугацаа хэтэрсэн төлбөрийн акт, албан шаардлагын судалгааг гарган аймгийн Прокурорын газарт хүргүүлэн ажиллаж байна.



Аймгийн хэмжээний шалгадагч байгууллагуудад Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, 2022 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын талаарх мэдээлэл, санхүүгийн тайлангийн аудитын нийтлэг илэрсэн алдаа зөрчил цаашид анхаарах асуудал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн сургалт, мэдээллийг өгч ажилласан Үүнд:



- Сайнишанд сумын ТШЗ болон нягтлан бодогчдын нэгдсэн сургалтад аудитын менежер У.Оюунтүлхүүр, Ч.Хэрлэнчимэг нар 2 удаа
- ХЦ-ийн дугаар 0168 ангид зохион байгуулсан хил хамгаалах байгууллагын бүсийн сургалтад дарга. тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий, аудитор Б.Уранбилэг
- Боловсролын системийн нягтлан бодогчдод аудитор Ч.Хэрлэнчимэг
- ЭМ-ийн байгууллагын нягтлан бодогчдод аудитын менежер У.Оюунтүлхүүр
- Байгууллагын нээлттэй өдөрлөгт дарга. тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий, аудитын менежер У.Оюунтүлхүүр

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд:

Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 2022 оны эхний хагас жилд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу холбогдох албан тушаалтнууд 2021 оны ХАСХОМ-ийг 2022.01.20-ны дотор гаргаж, баталгаажуулав.
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийг 2022.12.14-ний өдөр УАГ-т хүргүүлэв.

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу аудитор бүр санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитыг хийж гүйцэтгэхийн өмнө холбогдох мэдэгдлийг гарган дарга, тэргүүлэх аудитор баталгаажуулсан.
- Төрийн хяналт, шалгалтын стандартыг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмжийн 01 дүгээр хавсралтын дагуу аудит хийхийн өмнө сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг аудитор, аудитын менежер, дарга, тэргүүлэх аудитор тухай бүр гаргасан.
- Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн мэдээлэл сурталчилгаа, шторкыг байгууллагын social цахим хуудсаар байршуулан сурталчилж байна.
- Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх, авлигаас ангид байх ажлын хүрээнд авлигын эсрэг мэдээллийн самбарыг тогтмол шинэчлэн ажиллаж байна.
- Аудитын нээлт бүрд шалгагдагч байгууллагад аудитын төлөвлөгөө болон төрийн аудитын байгууллагын мэдээлэл авах эрх, шалгагдагч байгууллагын үүрэг, нөлөөллийн мэдүүлэг, авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгддэг ажлын талаарх холбогдох мэдээллийг танилцуулан ажиллаж байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд.


Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар дараах ажлыг хийж гүйцэтгэлээ Үүнд:

- Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл агуулсан баримтыг албан хэрэг хөтлөх зааврын бүртгэн, архивын нэгж үүсгэн ажилласан.
- Төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан баримтыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган баталгаажуулсан.
- Төрийн болон албаны нууцын хүрээнд хийсэн ажлын тайланг 2022.01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Дорноговь аймаг дахь Тагнуулын хэлтэс боон Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.
- Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааг 2022 оны 01 дүгээр сард бүх алба хаагчдаар гаргуулсан.
- Төрийн болон албаны нууц тээгчийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хадгалах, хамгаалах ажил хийгдэж байна.

Мэдээллийн ил тод байдлын хангах ажлын хүрээнд.

Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг “Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар” facebook хуудсаар 163 мэдээлэл, аудитын тайлан, үндсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг audit.mn, open.audit.mn цахим хуудсаар, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг “Шилэн дансны нэгдсэн систем”-д тухай бүр мэдээлж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар санал дүгнэлт гаргасан ТШЗ-ийн 108, ТБОНӨ компаниудын 9, ТТЗ-ийн 14 тайлан, ТЕЗ-ийн СТА, ТГТ 2 нийт 132 аудитын хураангуй тайланг www.tailan.audit.mn, open.audit.mn цахим хуудаст байршуулсан. Нууцад хамаарах 7 байгууллагын тайланг байршуулаагүй. Шууд тайлагнах аудитын 10 тайланг www.tailan.audit.mn, open.audit.mn цахим хуудаст байршуулсан.



ДОЛОО: САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



Тайлант онд 465.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 465.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 462.7 сая төгрөгийг зарцуулсан. Мөн нэмэлт санхүүжилтийн дансанд аудитын үйлчилгээний төлбөрт нийт 52.0 сая төгрөг, акталсан хөрөнгө борлуулсны орлого 0.03 сая төгрөг тус тус төвлөрсөн. Үүнээс гэрээгээр ажил гүйцэтгэсэн хувийн аудитын компаниудад 51.7 сая төгрөгийг зарцуулсан.

Мөн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, татварын болон НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.
- Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь, бүрэн оруулсан. Хагас жилийн байдлаар 60 мэдээллийг байршуулахаас хугацаа хоцорсон болон оруулаагүй мэдээлэл байхгүй.
- Зарцуулалтын эрхийн баталгаа болон сарын мэдээг хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, баталгаажуулсан.
- Сангийн яамнаас зохион байгуулсан “Эрхийн бүртгэлийн системийн цахимжуулалт” сэдэвт сургалтад дарга, тэргүүлэх аудитор, нягтлан бодогч нар хамрагдаж 2022.04.08-ны өдрөөс эхлэн ТАЦНС-ийн гарт олгох цалингийн гүйлгээг цахимаар шилжүүлдэг болсон.
- 2023 оны төсвийн төслийн төсөөллийг бэлтгэж, ҮАГ-т хугацаанд нь хүргүүлсэн.
- 2010-2021 онуудад хийгдсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний судалгааг архивын баримтаас бэлтгэж, ҮАГ-т хугацаанд нь хүргүүлсэн.
- 2019-2021 оны Төрийн аудитын байгууллагын албан хаагчдад хөнгөлөлт, буцалтгүй тусламж, нөхөн олговор олгосон судалгааг гаргаж, ҮАГ-т хугацаанд нь хүргүүлсэн.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн хагас жилийн тооллогыг дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар ажлыг хэсгийг томилон гүйцэтгэлээ. ТӨБЗГ-ын 2022 оны 296 дугаар тогтоолын дагуу байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,351.8 мянган төгрөгийн 5 нэр төрлийн машин, тоног төхөөрөмжийг актлав.
- Байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд “Мишээл-Од аудит” ХХК аудитыг хийж гүйцэтгэн “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн. Аудитын тайланд 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн хэрэгжилтийг хүргүүлсэн.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтөлж, 2019 оноос НББ-ийн үйл ажиллагаанд санхүүгийн “Unicus” программыг ашиглаж байна.

НАЙМ: ДҮГНЭЛТ, САНАЛ



ДҮГНЭЛТ

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан ТАБ-ын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, 2022 онд дэвшүүлсэн зорилтыг баримтлан ажиллаа.

- ТАБ-ын 2022 оны зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.
- Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, стратегийн хүрээнд нийт 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг бүрэн хангасан.
- Санхүүгийн тайлангийн аудит 231, ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудит 1, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит 3, нэмэлтээр хийх төлөвлөгөөт бус 3, өөрийн санаачилгат 2, өмнөх оноос шилжиж ирсэн 1, Хуульд заасан “Орон нутгийн төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитыг тус тус хугацаанд нь гүйцэтгэж дуусган, холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсэн.
- Тайлант онд нийт 69,869.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 38,220.0 сая төгрөгийн 435 алдааг залруулж, 126.3 сая төгрөгийн 51 төлбөрийн акт тогтоож, 17,539.5 сая төгрөгийн 250 албан шаардлага, 13,983.2 сая төгрөгийн 366 зөвлөмж, 7 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.
- Өмнөх оны үлдэгдлээс 12.8 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 5,058.9 сая төгрөгийн 23 албан шаардлага, 5,881.5 сая төгрөгийн 129 зөвлөмж хэрэгжсэн.
- Тайлант хэрэгжвэл зохих 51 төлбөрийн актаас 40 барагдаж 78 хувьтай, 242 албан шаардлагаас 223 хэрэгжиж 92.1 хувьтай, 346 зөвлөмжөөс 313 хэрэгжиж 90.4 хувийн биелэлттэй байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 9-18 хувиар өссөн байна.
- Тайлант хугацаанд нийт 18,905.2 сая төгрөгийн үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд нэг төгрөг ногдох үр өгөөж 40.9 төгрөг байна. Энэ нь өмнөх оны үр өгөөжөөс 3 дахин өссөн байна.
- Төрийн хяналтын 100 жилийн ойн төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн.
- Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжийг мөрдөж ажилласан.

САНАЛ

Тайлант хугацааны үйл ажиллагаатай холбоотой дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх аудитын төлөвлөгөө хөтөлбөрт АНТАГ-ын гүйцэтгэх хугацааг нарийн тооцоолж оруулж байх.

2. Санхүүгийн тайлангийн системд санхүүгийн тайлан /стаус-аар буулгасан файл/-г оруулдаг болгож материаллаг түвшин, санхүүгийн тайлангийн шинжилгээг системээр гаргадаг болгох.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд ойрын болон хэтийн бодлого, төлөвлөгөөнд тусгах санал санаачилгатай холбоотой

1. Албан хаагчдыг гадаадын сургалтад үе шаттайгаар хамруулж, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлснээр аудитыг илүү үр өгөөжтэй, үр нөлөөтэй гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

ЕС. ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

1. Байгууллагын 2022 оны статистик мэдээ
2. Аудитаас бий болсон үр өгөөжийн тайлангийн нэгтгэл

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ